



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХҮДЭР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2020 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 153 .

Булагтай


Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны
ажлын төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалтыг баримтлан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 29 дүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг 88,9 хувьтай, “хангалттай” гэж дүгнэсүгэй.


2. Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны үйл ажиллагаа, гүйцэтгэлийн төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

ДАРГА



ТЭРДЭНЭБАТ

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2020 оны 01-р сарын 24-ний өдрийн
153 дугаар тогтоолын хавсралт.




ХҮДЭР СУМЫН ИТХ-ЫН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

ИТХ-ын 2020 онд хэрэгжүүлэх зорилтууд:

1. Сумын ИТХ-ын сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлсэн стратеги төлөвлөгөөний биелэлтийг хангах, хэрэгжилт үр дүнг тооцох, сурталчлах
2. Хурлаас гарах шийдвэрт иргэдийн оролцоог хангах, саналыг тусгах ажлыг зохион байгуулах, хяналтыг дээшлүүлж, үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах
3. ИТХ-ын тогтоол шийдвэр, үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг иргэдэд шуурхай хүргэх ажлыг тогтмолжуулж, чанаржуулах

№	Хийж, хэрэгжүүлэх ажил, асуудлууд	Хугацаа	Асуудал оруулах, хариуцах албан тушаалтан	Биелэлт
Нэг. Сумын ИТХ-ын хуралдааны талаар				
1.	Сумын ИТХ-ын хуралдааныг зарлан хуралдуулж, хууль тогтоомжийн дагуу өргөн барьсан асуудал, дэвшүүлсэн саналыг тухай бүрд нь хэлэлцүүлж байх	Жилдээ 4-өөс доошгүй удаа	Сумын ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид Засаг дарга	
2	Сумын ИТХ-ын онцгой бүрэн эрхэд хамаарах бусад асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэх	Тухай бүр	Асуудал санаачлагч	
Хоёр. Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурал, хэлэлцэх асуудал				
1	-ГХУСАЗС3-ийн тайланг хэлэлцэх -Хуралдааны тов зарлах -Сум хөгжүүлэх сангийн зээлийн чиглэл тогтоох -2017-2019 онуудад төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудын гүйцэтгэл, үр дүн, төсвийн гүйцэтгэлийн тухай сонсгол	1-р сар	ИТХ-ын дарга Ажлын алба Сумын Засаг дарга	
2	-“Эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэх жил”-ийн хүрээнд зохион байгуулах ажлын тухай Засаг дарга сонсгол -ИТХ-ын шагналаар шагнагдах байгууллага иргэдийг тодруулах -УИХ-ын сонгуулийн зохион байгуулалттай холбоотой асуудлууд	2-р сар	ИТХ-ын ажлын алба, Засаг дарга, ЭМТ-ийн эрхлэгч	
3	-Сумын ЭМТ-ийн үйл ажиллагааны тухай сонсгол -Хяналт шалгалтын ажлын хэсэг байгуулах тухай /Шанд ургац ХХК-ийн тариалангийн газрын асуудлаар/ -“Эхийн алдар” болон төрийн одон медальд тодорхойлох	3-р сар	Засаг дарга ИТХТ-ийн нарийн бичгийн дарга	
4	- Ойн анги, байгаль орчны албадын үйл ажиллагааны тухай мэдээлэл	4-р сард	Сумын Засаг дарга,	

5	-БОХ дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлах тухай -Хяналт шалгалтын ажлын дүгнэлт, үр дүнгийн тухай /Шанд ургац ХХК-ийн тариалангийн газрын асуудлаар/ -Нутгийн захиргааны байгууллагаас хүний эрхийг хангаж байгаа байдал, хэрэгжүүлж буй арга хэмжээний биелэлтийг тайлан	5-р сард	БО-ны алба Ойн анги Ажлын хэсгийн ахлагч НУХЭЗЭЗ хороо	
6	-Соёлын талаар баримтлах бодлого хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын тухай сонсгол -Хүдэр сумын эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөө /2014-2023он/-ний хэрэгжилтийн 2-р үе шатны хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын тухай -НД-ын ажлын тухай, тэтгэвэр тогтоолтын байдал, иргэдийн СӨГ, түүний барагдуулалтад хийсэн шалгалтын ажил	6-р сар	ИТХ-ын ажлын алба, Засаг дарга, ТГазар Соёлын төв Хурлын НБХороо НДаатгал	
7	-Сумын ИТХ-ын хурал, тэргүүлэгчдийн тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тухай -ГХУС ажлын эхний хагас жилийн тайлан -төсвийн эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайлан	7-р сар	ИТХ-ын дарга Засаг дарга ГХУСАЗСЗ	
8	-Өвөлжилтийн бэлтгэл, хадлан тэжээл бэлтгэх ажлын тухай -“Эрүүл аюулгүй орчны бүрдүүлэх жил” зорилгын хүрээнд зохион байгуулсан ажил, үр дүнгийн тухай сонсгол	8-р сар	Засаг дарга, БЗД нар ЗДТГ ХАА-н тасэг	
9	-ЕБСургууль, цэцэрлэгийн хичээлийн жилийн бэлтгэл, сурах орчин нөхцөл бүрдүүлэлт, өвөлжилтийн бэлтгэлийн тухай -ОНХС-аар хийгдэж буй ажлын явц, үр дүн, хяналт тавих ажлын хэсгийн тайлан	9-р сар	Засаг дарга, ЕБС захирал, Цэцэрлэгийн эрхлэгч Ажлын хэсэг	
10	-СХСангийн 2020 оны төсвийн гүйцэтгэлийн явц, зээл олголтын тухай -ИТХ-ын сонгуулийн үр дүнгийн тухай сонсгол	10-р сар	ИТХ-ын дарга ИТХ-ын ажлын алба Засаг дарга	
11	-Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажлын хэсгийн тайлан	11-р сар	Ажлын хэсэг, Засаг дарга	
12	-ГХУСАЗСЗ-ийн 2020 оны ажлын тайлан -Сумын ИТХ-ын тогтоол шийдвэрийн хэрэгжилт, үр дүнгийн тухай	12-р сар	ИТХ-ын дарга, ИТХТ-ийн НБД	
13	Хуулиар сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн бүрэн эрхэд хамаарах бусад асуудал болон цаг үеийн шаардлагатай асуудлууд: -ИТХ-ын хуралдааны тов зарлах, ажлын хэсэг байгуулах, хяналт шалгалт гэх мэт.	Тухай бүр нь	Асуудал санаачлагч	
Гурав. Хяналт шалгалтын ажил				
01	НЗБ-аас иргэдийн СӨГ-ыг барагдуулалт, хүний эрхийг хангах талаар хэрэгжүүлж буй арга хэмжээ, биелэлт, үр дүнг шалган танилцах, ИТХТ-ийн хуралд танилцуулах	2-4-р сард	Нутгийн удирдлага, хууль зүй, ёс зүйн хороо	

02	НД-ын хууль тогтоомжийн хэрэгжилт, иргэд ӨН-ы тэтгэврээ цаг хугацаанд нь тогтоолгож байгаа эсэхэд хяналт шалгалт хийж, дүнг ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулах	Эхний хагас жилд	Нийгмийн бодлогын хороо, ҮЭХ хамтран	
03	Сумын төсвийн гүйцэтгэлийн тайланд хагас, бүтэн жилээр хяналт шалгалт хийх	2 удаа	Эдийн засаг, төсөв санхүүгийн бодлогын хороо	
04	Өмнөх жилүүдэд хийсэн ойжуулалттай шалган танилцах ажлыг гүйцээж хийх	2-р улирал	ХААБО-ы бодлогын хороо	
05	Ойн сангаас нь хууль бусаар мод бэлтгэгдэж байгаа нөхөрлөл, ААН-ийн ойн санд хяналт шалгалт хийх /Шанд, Тарвагатай, Бумбат, Төмөртэй/	2-р улирал	ХААБО-ны бодлогын хороо	
06	Уул уурхайн ашиглалт хийгдэж байгаа газруудтай шалган танилцах	Жилдээ	ХААБО-ны бодлогын хороо	
07	ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрээр ажлын хэсэг байгуулан хяналт шалгалтын ажил зохион байгуулах	жилдээ	ИТХ-ын Тэргүүлэгчид	
Дөрөв. ИТХ-ын төлөөлөгчид, тэргүүлэгчид, ИТХ-ын хороодтой ажиллах талаар				
01	ИТХ-ын төлөөлөгчдөд хууль эрх зүйн сургалт зохион байгуулах, хамруулах	Жилдээ 2-оос доошгүй	Хурлын дарга, нарийн бичгийн дарга	
02	ИТХ-ын хуралдаанаар хэлэлцэх асуудлыг хороод урьдчилан хэлэлцэж хэвших, хороодын гаргасан дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг тооцох	Тухай бүр	Бодлогын хороодын дарга нар, ажлын алба	
03	Шинээр сонгогдсон төлөөлөгчдөд ИТХ-ын эрхлэх асуудал, бүрэх эрхтэй холбоотой хууль тогтоомжийг эмхэтгэн эрх зүйн гарын авлагатай болгох	Жилдээ	ИТХТ-ийн Ажлын алба, ЗДТГ	
Тав. НӨУЁБ-ын мэдээлэл, сурталчилгаа				
1	Багийн ИНХ-ын хуралдаан болон нийтийг хамарсан зөвлөгөөн дээр хууль тогтоомж, ИТХ-ын тогтоол шийдвэр болон шаардлагатай мэдээ, мэдээллийг танилцуулах, сурталчлах	Тухай бүр нь	ИТХ-ын дарга, ажлын алба	
2	Сумын ИТХ-ын мэдээллийн самбарыг шинэчлэх, хурлын үйл ажиллагааны мэдээллийг самбарт болон www.khural.mn цахим сайтаар сурталчлах, тус сайтын үйл ажиллагааг тогтмолжуулж ажиллах	тогтмол	ИТХ-ын НБДарга, ГХУСАЗСЗ-н ажилтан	
3	Сумын ИТХурал, Тэргүүлэгчдийн 2019 оны тогтоол шийдвэрийн эмхэтгэлийг хэвлүүлэн төлөөлөгчид, байгууллагууд, багуудад хүргэх	2-3-р сард	Ажлын алба	
4	Хурлаас гарах шийдвэрийн талаар иргэдийн санал авах хэлэлцүүлэг болон сонсох ажиллагаа зохион байгуулах	Жилдээ тухай бүр нь	Ажлын алба	

Зургаа. Багийн ИНХ-ын үйл ажиллагаанд зөвлөн туслах ажил				
1	ИНХ-ын 2020 оны ажлын төлөвлөгөөг гаргуулж биелэлтийг хангуулах, НӨУБ-ын үйл ажиллагааны талаар мэргэжил арга зүйн зөвлөмж, мэдээлэл өгөх, сургалт зохион байгуулах	1 сард	ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга	
2	Багийн ИНХ-ын хуралдаан болон Тэргүүлэгчдээс дэвшүүлсэн саналыг сумын ИТХ-аар хэлэлцүүлэх, хариуг хүргүүлэх	Жилд	Сумын ИТХ-ын дарга	
3	Багийн ИНХ-ын анхдугаар хуралдааныг зохион байгуулахад мэргэшил арга зүйн туслалцаа дэмжлэг үзүүлэх	4-р улирал	ИТХ-ын НБДарга	
Долоо. ИТХ-ын дотоод ажлын талаар:				
1	ИТХ-ын болон Тэргүүлэгчдийн хурлын бэлтгэл, зохион байгуулалтыг хангах	Тухай бүр нь	ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга	
2	ИТХ-д ирүүлсэн иргэдийн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авч бүртгэх, хариуг хүргүүлэх	Тухай бүр нь	ИТХ-ын дарга, НБД	
3	ИТХ-ын бичиг баримтыг эмхлэн байнга болон түр хадгалах архивын нэгжийг архивд авах, хадгалах хугацаа дууссан архивын зарим баримтыг ББНШК-ын дүгнэлтээр устгах	Жилд	Нарийн бичгийн дарга, ГХУС ажилтан	
4	Сумын ИТХ-ын бүрэн эрхэд хамаарах цаг үеийн шаардлагатай ажлуудыг зохион байгуулах, хэрэгжүүлэх	Тухай бүрд нь	Ажлын алба	
Найм. ИТХ-ын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх бусад ажлууд				
1	ГХУС ажлыг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах	жилд	ИТХ-ын дарга ажилтан	
3	Анхан шатны УЗ Хорооны ажлыг зохион байгуулах, татварыг оны эхнээс жигд төвлөрүүлэх, УЗХ-ны 2019 оны тайлагнах	жилдээ	ИТХ-ын дарга, НБДарга	
4	"Алдарт эх"-ийн одон гардуулах үйл ажиллагааг зохион байгуулах	06 –р сард	ИТХ-ын дарга НБД	
5	Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн өдрийг тэмдэглэх, хэлмэгдэгсдийн үр хүүхэд, ач зээ нарт хүндэтгэл үзүүлэх	9-р сард	Ажлын алба	
6	Орон нутагт сайн засаглалыг бэхжүүлэх, Авлигатай тэмцэх тухай болон НАНБХАСЗАСЗАБ тухай хууль, холбогдох тогтоомжуудыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллах	1-р сард, Жилдээ	ИТХТ-ийн нарийн бичгийн дарга /ЭБАТ/	
7	УИХ-ын болон аймаг, сумын Хурлын сонгуулийн бэлтгэл зохион байгуулалтыг хангах	Жилдээ	ИТХ-ын НБД	

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛСАН:
СУМЫН ИТХ-ЫН АЖЛЫН АЛБА